



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/49

Дэлгэрхаан сум

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалт, халдваргүйтгэл, лабораторийн
шинжилгээ хийх ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5, 6.6 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.5, 9.6, 9.8 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн малын өвчлөл, эпизотологийн судалгааг үндэслэн голомтот бүс нутгийн мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж дархлаажуулах, лабораторийн оношлон, тандах шинжилгээний ажлыг хариуцсан баг, өрхөд графикт хугацаанд нь зохион байгуулж ажиллахыг "Батмэнд сүрэг", "Цагаан тан эрдэнэ", "Баянхааны сүрэг", мал эмнэлгийн аж ахуйн нэгжүүдийн захирал, малын эмч (Ч.Хоролмаа), (С.Сарантуяа), (О.Батболд) нарт үүрэг болгосугай.

2.Багийн малчдад урьдчилан мэдэгдэж зар хүргэх, малчдын малыг бэлэн байлгах, тарилгын хашаа хоолойг малчдаар бэлтгүүлэх, малчид, мал бүхий иргэдийг татан оролцуулж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

3.Шаардагдах вакцин эм бэлдмэлийг татан авч мал эмнэлгийн аж ахуй нэгжүүдэд хуваарилах, мэргэжил арга зүйгээр хангаж, тарилгын явц, гүйцэтгэлд хяналт тавьж, мал эмнэлгийн арга хэмжээнд мал сүргээ бүрэн хамруулаагүй хамруулахаас зайлсхийсэн, заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бий болгосон иргэд, албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцох, тарилгын материалыг хугацаанд нь хүргэж ажиллахыг мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч (Д.Баярмаа)-д хариуцуулсугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Батнасан)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН



